

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2013 ОНЫ

1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2013.04.29.

Улаанбаатар хот

Нэг. Тухайн жилийн зорилт, биелэлт, үр дүн

Дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх 5А хөтөлбөрийн хүрээнд 74 заалт, 234 хэрэгжүүлэх үйл ажиллагаатайгаар төлөвлөн ажиллаж байна.

Хоёр. Дүүргийн нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлого, зохицуулалт

2.1. Төсвийн орлогын талаар:

Орон нутгийн төсвийн орлогоор 2013 оны 3 дугаар сард төлөвлөгөө 2 тэрбум 68.6 сая төгрөг байхаар төлөвлөснөөс өнөөдрийн байдлаар 2 тэрбум 187.3 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 118.7 сая төгрөгөөр давуулж, 105.7 хувиар биелүүлээд байна.

2.2. Төсвийн зардлын гүйцэтгэлийн талаар:

2013 оны орон нутгийн төсвийн байгууллага 2.1 тэрбум, тусгай шилжүүлгээр 9.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгодсон. Төлбөр тооцооны мэргэжилтнүүд, төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нартай хамтран 2013 оны эхний 3 сарын олгодсон санхүүжилтийн хүрэлцээ төсвийн тооцоо хийж, өр авлага гарах эсэх талаар судлан ажиллаж байна.

2.3. Мэдээ, тайлангийн талаар:

Нийслэлийн өмчийн харилцааны газартай хамтарч Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, 21 өрхийн эмнэлэг, 7 төр захиргааны байгууллага, 18 сургууль, 30 цэцэрлэг өмч эзэмшлийн гэрээг 100 хувь байгуулж нийт 76 байгууллагын өмч хөрөнгийн нэгтгэл хийж, Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлсэн.

Нийт 109 төсөвт байгууллагын эхний 2 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч нэгтгэж, нийслэлийн төрийн санд хуулийн хугацаанд хүргүүлээ.

2.4. Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн талаар:

- Баянгол дүүргийн эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтын хүрээнд Хэлтсийн болон хэлтсийн ажилтнуудын төлөвлөгөө гарган, Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 5А ажлын хүрээнд нийт 32 багц зорилтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан энэ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дүгээр хэсэгт заасны дагуу ЗДТГ-ын ажилтнуудыг оролцуулан ХАА-ны "АЗ" гэрчилгээ олгох зорилгоор ШУТИС-ын КТМС-ын багш нар 2013 оны 02 дугаар сарын 04-06-ны хооронд сертификаттай сургалтыг зохион байгууллаа.

- “Олон нийтийн оролцооны аргаар хөрөнгө оруулалтыг төлөвлөх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд НХОГ-ын Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Эгиймаа, БГД-ийн Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчид, хороодын засаг дарга нар оролцов.

- БГД-ийн Засаг даргын А/99, А/141, А/154 захирамжийн дагуу 2013 он болон 2014-2016 онуудад Баянгол дүүрэгт хийгдэх Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, он дамжсан хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын тооцоо судалгаа гаргах, төлөвлөх Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж тооцоо, судалгааны ажлаа нэгтгэн ажиллаж байна.

- Улаанбаатар хотын гэр хорооллыг орчин үеийн барилгажсан хороолол болгон хөгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний дагуу сонгосон гэр хорооллуудыг инженерийн болон бусад дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэхэд дэмжих зорилгоор “Гэр хорооллын дахин төлөвлөлт” сэдэвт уулзалт-семинарыг 2013.03.07-нд зохион байгууллаа. Уулзалт-семинарт БГД-ийн ЗДТГ-ын Удирдах ажилтнууд, Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар, БГД-ийн ЗДТГ-ын ДБТХ, ЭЗТХ, БГД-ийн хороодын засаг дарга нар хамрагдлаа.

- НХОГазарт ирэх 3 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулахад дүүргүүдийн 23 хороо тус бүрээс мэдээлэл цуглуулж, хөрөнгө оруулалтын судалгааг мэдээллийн цахим хэлбэрээр болон цаасаар гарган гарын үсгээр баталгаажуулж 2013-2016 оны хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөнд тусгуулсан.

- 2013-2016 онд БГД-т хэрэгжүүлэх Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаархи саналыг олон нийтийн нээлттэй санал асуулга, хэлэлцүүлгийг зохион байгуулж, Төсвийн тухай хуулиар заагдсан дүүргийн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг дарааллаар эрэмбэлж, ДИТХ-д өргөн мэдүүлсэн.

- УИХ-ын 2012 оны 60 дугаар тогтоолын 4 дүгээр заалт, ЗГ-ын 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны 7 дугаар тэмдэглэлд заасныг хэрэгжүүлэх зорилгоор Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар ирүүлсэн саналыг газар дээр нь очиж нягтлан эрэмбэлэх, барилга байгууламж, объектын талаархи бодит мэдээллийн сан бүрдүүлэх үүрэг бүхий ЭЗХЯ, ҮХААЯ, СЯ, БХБЯ-ны хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, ЗДТГ болон ИТХ хамтран идэвхтэй оролцож дээрх ажлыг хамтран зохион байгуулсан.

Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн ажил:

Баянгол дүүрэгт 2013-2016 онуудад Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, гадаадын зээл, тусламж төсөл хөтөлбөрөөр нийт 367 ажил хийгдэхээр төлөвлөөд байна.

2013-2016 онуудад Боловсролын салбарт улс, нийслэл, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх шаардлагатай ажлын жагсаалтын тооцоо, судалгаа гаргаж нэгтгэсэн.

БГД-т 2013 оны 03 дугаар сарын байдлаар 6 төсөл арга хэмжээнд нээлттэй тендер зарлаж, холбогдох урилгуудыг e-procurement.mn, Үндэсний шуудан сонинд тавьсан.

БГД-ын ЗДТГ-аас 2012-2013 онд он дамжин хийгдэж байгаа нийт 1270,0 сая төгрөгний 11 ажлаас 1060,1 сая төгрөгний 5 ажилд нээлттэй тендер зарласан ба 3 дугаар сарын 25-26 ны өдрүүдэд нээж, 209,4 сая төгрөгний 6 ажилд харьцуулалтын тендер зарласан.

2013 оны 03 дугаар сарын байдлаар Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7 төсөл арга хэмжээнд нээлттэй тендер зарлагдсан.

Мөн НЕТГ-т 9, 21, 23-р хороонд нийт 3 худаг барих ажлын төсвийг суулган зураг, төслийн шатандаа явж байна.

Гэр хорооллыг дахин төлөвлөх ажлын хүрээнд 1, 2, 3, 4, 20-р хорооны байрнуудад судалгаа хийж, ашиглалтын шаардлага хангахгүй эсэх талаар дүгнэлт гаргуулах ажлыг МХХ, ХЗД-тай хамтран ажиллаж байна.

БГД-ийн 7, 9, 20-р хорооны айл өрхөөс судалгаа авч иргэдийн санал хүсэлтийг авч, дахин төлөвлөх ажлыг эхлүүлээд байна.

Дүүргийн хэмжээнд 2013-2016 онд хийх шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлыг Шинэ барилга, их засвар, гэрэлтүүлэг тохижилт гэсэн ангиллаар гаргаж Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт хүргүүллээ.

Хөрөнгө оруулалтын ажлын талаар:

ᠶᠡᠳᠡᠶᠢ ᠶᠡᠳᠡᠶᠢ хөгжлийн сангийн ᠔᠐᠔᠐ᠶ᠋ᠠ᠋᠋ ᠶᠡᠳᠡᠳᠡᠳᠡᠳᠡᠳᠡ ᠔᠙᠙᠔ 2,879,5 сая төгрөгний ажлын задаргааг ИТХ-аар батлуулан Үнэлгээний хороо байгуулах шатандаа явж байна.

Сангийн яамны худалдан авах ажиллагааны бодлогын газартай хамтран Засгийн газрын худалдан авах ажиллагааны 3 хоногийн сургалтыг явуулахаар саналаа явуулсан.

Гурав. Нийгмийн хөгжлийн бодлого зохицуулалт

3.1. Нийгмийн халамж үйлчилгээний чиглэлээр:

Нийгмийн халамжийн тухай болон Ахмад настан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэр, бусад эрх зүйн акт баримтыг ханган хэрэгжүүлэх, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх төрийн үйлчилгээг хуулийн дагуу үзүүлдэг. Үүнээс:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр- 2369 иргэн
- Асаргааны мөнгөн тэтгэмж –1527 иргэн
- Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж- 1756 иргэн
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ- 50 иргэн
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт-1961
- Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт- 3760 иргэн
- Эх, хүүхдэд олгох тэтгэмж, хүүхэд, эх, гэр бүлд олгох мөнгөн тусламж–14080 иргэн
- Алдар цолтой ахмад настанд төрөөс огох нэмэгдэл- 355 иргэн
- Хүний хөгжил сангаас хишиг хувь хүртээх тус тус ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 125 иргэн нийтдээ 25983 иргэн нийгмийн халамжийн тусламж дэмжлэгэд хамрагдсан байна.

3.2. Нөхдөг арга хэмжээнд, нийгмийн хүн амын байдлаар хүрээг өргөтгөх чиглэлээр:

1-р улиралд нийт хандуулаа, чийрэгжүүлэх төвүүдээр нөхдөг арга хэмжээнд нийгмийн хүн амын байдлаар хүрээг өргөтгөх чиглэлээр 4 арга хэмжээ зохион байгуулахаар, давхардсан тоогоор 47 байгууллагын 2420 гаруй хүний байдлаар нийгмийн хүн амын байдлаар хүрээг өргөтгөх чиглэлээр.

10 удаагийн тэмцээн зохион байгуулж, үүнд давхардсан тоогоор 102 байгууллагын 4050 хүн хамрагдсан байна.

Нийслэл болон Улсын аварга шалгаруулах 8 удаагийн тэмцээнд оролцож, нийт 8 алт, 8 мөнгө, 8 хүрэл медаль хүртсэн.

Дүүргийн хэмжээнд хуваарийн дагуу 24 байгууллагын өвлийн өдөрлөг зохион байгуулагдсан. 3 удаагийн өвлийн өдөрлөгт оролцож, 2 удаа 1-р байр эзэлсэн.

Улс, нийслэлээс зохион байгуулсан 6 удаагийн 14 өдрийн сургалт семинарт 70 багш, дасгалжуулагч, мэргэжилтэн төлөөлөгчдөө хамрууллаа.

Дүүргийн 7-р хорооны нутаг дэвсгэр дээр 3 зам бүхий усан бассейн баригдаж байна. Бассейны дотор заслын ажил хийгдэж 5-р сард багтаан ашиглалтанд оруулна. Тоног төхөөрөмж нь нийлүүлэгдсэн.

3.3. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Ажлын байрны зар мэдээлэл захиалгыг цахим хэлбэрээр иргэдэд хүргэх зорилгоор 23 хорооноос Е-Бирж ажиллуулахаас 18 хороонд суурилуулан ажиллуулж байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээлэл зөвлөгөөний өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж нийт 946 иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээ мэдээллээр хангасан болно.

Дүүргийн засаг даргын захирамж, албан тоотын дагуу Тамгын газартай гэрээ байгуулан 23 хороонд цэвэрлэгээ үйлчилгээний ажилтнуудыг ажиллуулан 2-р сард ажилласан 62 ажилтны ажлын хөлсийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон.

Дүүргийн хэмжээнд шинээр 51 ажил олгогч байгууллагаас 1503 ажлын байрны захиалга хүлээн авч, ажил хайгч, ажилгүй 325 иргэнийг бүртгэж, 118 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан.

Ажил олоход хүндрэлтэй иргэн болон ажилгүй, мэргэжилгүй 49 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамруулсанаас ажил олгогчтой дөрвөлсөн гэрээ байгуулан 16 иргэнийг сургалтанд хамруулсан.

“Ажилтай орлоготой Монгол хүн” нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, 17 аж ахуйн нэгж байгууллага, 26 сургалтын төв, 2 МСҮТ оролцож, хувиараа хөдөлмөр эрхлэгч 6 хүн хийсэн бүтээлээрээ үзэсгэлэн гаргав. 160 хүнд АМЧБОлгох зөвлөгөө, 47 хүн ХЭСургалтанд бүртгүүлж, 50 хүнд ЖДҮйлдвэрлэл эрхлэх чиглэлээр, 59 хүнд Төсөл хөтөлбөрүүдийн талаар, 37 хүнд ХЭДС-ийн зээлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд аж ахуй эрхлэлтийн сургалтанд 19 хүнийг явуулаад байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих жижиг зээлийн хүрээнд 4 иргэн, 2 нөхөрлөлийг хамруулан Капитал банкаар нийт 33.0 сая төгрөгийн зээл олгогдоод байна.

3.4. Эрүүл мэндийн чиглэлээр хийгдсэн ажил үйлчилгээнүүд:

БГЭМН-ийн даргын 75 тоот тушаалаар “Тамхины хяналтын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулж 10 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан, хууль болон тамхины хор хөнөөлийн талаарх сурталчилгаа, мэдээллийг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 224 тоот тогтоол, Монгол Улсын Эрүүл Мэндийн Сайдын 274 дүгээр тушаал “Эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үндэсний стратеги”-ийн дагуу иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох

ажлын төлөвлөгөө гарган батлуулж, эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион байгуулж байна. Дүүргийн хэмжээнд явуулсан сургалтын тоо 46, сургалтанд хамрагдсан хүний тоо 9260, зохион байгуулсан өдөрлөгийн тоо 2.

“Цахилгаан түгээх сүлжээ хэрэглэгчдэд үйлчлэх төв”-ийн ажилчдад Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх талаар болон Чихрийн шижин, хавдар, зөв хооллолт болон дасгал хөдөлгөөн, архи тамхины хор уршиг сэдвүүдээр сургалт хийж, чихрийн шижингийн эрсдлийг үнэлэх, тест авч үр дүнг тооцлоо.

Эрүүл мэндийн нэгдлийн цогцолбор барилга баригдаж байна.

100 ортой ЭМН-ийн цогцолборын яаралтай тусламжийн тасагт ашиглагдах 450 сая төгрөгний оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмжийн асуудлыг Нийслэлийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж тендерт зарлагдах бэлтгэл ажил хангагдлаа.

Үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээг чанартай хүргэхэд эмч нарын мэдлэг, мэргэшил, хандлагыг сайжруулах зорилгоор ажлын байранд 22 удаагийн тасралтгүй сургалт явуулах төлөвлөгөө боловсруулан 3 удаагийн сургалтыг явуулаад байна.

Цогцолбор байргүй 4, 12, 13, 17, 18-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүдээс “Угтахуй” ӨЭМТөвийн барилга баригдаж байна.

Сувилахуйн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн болон эмчилгээний сувилахуйн чиглэлийг сайжруулах зорилгоор УНТКЭ-ийн “Яаралтай тусламжийн тасаг”-т, “Сонгдо” ОУ-ын эмнэлэгт 36 сувилагчийг сургалтанд хамрууллаа.

3.5. Боловсролын чиглэлээр:

162-р цэцэрлэг нь хүүхдийг байгаль орчинтой танилцуулах зорилгоор багш ажиллагсдын хамтын хүчээр гаднах талбайг “Ногоон орчин” болгон тохижуулж, цэцэрлэгтээ бичил музей байгуулсан.

ЕБС-ийн сурагчдыг гэмт хэрэг, архи тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн нийгмийн ажилтнууд ЗБТГазартай хамтран тамхины шинэ хуулийн талаар ахлах ангийн нийт 58 сурагчдын дунд сургалт зохион байгуулж, чөлөөт ярилцлага зохион байгуулсан. ЕБСургуулийг архи, тамхигүй орчин болгох зорилт тавин ажиллаа. Энэ чиглэлээр ажиллах ажлын төлөвлөгөөг дүүргийн цагдаагийн I, II хэлтэстэй хамтран ажиллах ажлын төлөвлөгөө боловсруулсан.

13-р сургууль, “Гурван тамир” сургууль эцэг эхийн дэмжлэгтэйгээр 47-р сургууль, 19-р сургуулийн төв зам дээр хурд сааруулагчийг шинээр хийж, “Сэтгэмж” цогцолбор сургууль замын тэмдэг тэмдэглэгээ хийсэн.

Сургууль бүрийн орчны авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс сургуулийн багш эцэг эх хамтран хуваарь гаргаж түр зохицуулагчийг хуваарийн дагуу ажиллуулж байна.

164-р цэцэрлэг нь хүүхдийн авьяасыг хөгжүүлэх зорилгоор бүжгийн дугуйланг тогтмол хичээллүүлж, уран хөдөлгөөнт гимнастикийн уралдаанд улсад сүүлийн 10 жил тэргүүн дэд байруудыг эзэлсэн амжилттай ажиллаа. Эцэг эх дүүргийн цэцэрлэгүүдэд тоглолт хийж үйл ажиллагаагаа сурталчилж байна. Ерөнхий боловсролын сургуулиуд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх зорилгоор авьяас хөтөлбөрийг хэрэгжүүлж буй дүүргийн төрийн ба төрийн бус өмчийн 46 сургуулиуд хичээлээс гадуур сурагчдын дунд сургалт,

лекц, өдөрлөг, тэмцээн, уралдаан, үзэсгэлэн зэрэг 6 төрлийн арга хэмжээг зохион явууллаа. Энэ зохион байгуулсан үйл ажиллагаагаа хэвлэл мэдээллээр 65 удаа сурталчилсан.

“Авьяас хөтөлбөр” –ийн хүрээнд СӨБ-ийн 700 хүүхдийн “Аз жаргалтай аялгуу” урлагын тоглолтыг МҮЭСТО-нд 2013 оны 04 дүгээр сарын 27-ны 12 цагаас зохион байгууллаа.

3.6. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын-шинэчлэл бодлого” үндэсний чуулганыг угтсан “Оролцоог бодит болгоё” сарын аяны хүрээнд зохион байгуулагдсан ажлын хүрээнд:

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын бодлого-шинэчлэл” анхдугаар чуулганыг угтан “Оролцоог бодит болгоё” сарын аяны нээлтийг 2013 оны 04 дүгээр сарын 11-нд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 92 төлөөлөл, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо ТББ, Засаг даргын тамгын газрын харьяа хэлтсүүдийн бүрэлдэхүүн оролцлоо.

2013 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын тэмцээнийг Баянгол дүүргийн Спорт хороотой хамтран 70-р сургуулийн спорт зааланд зохион байгууллаа.

“Оролцоог бодит болгоё” сарын аяны хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөг, гар урлалын үзэсгэлэн худалдааг Өргөө кино театрын урд талбай, Төмөр замын дээд сургуулийн урд талбайд 2 удаа зохион байгуулж, энэхүү арга хэмжээнд харьяа хэлтсүүд үйл ажиллагаагаа иргэдэд нээлттэй, шуурхай сурталчиллаа. Энэхүү өдөрлөгийн арга хэмжээнд 23 хорооны 150 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн гар урлалын бүтээлээрээ үзэсгэлэн гаргасан бөгөөд 5000 гаруй иргэд өргөнөөр оролцлоо.

Баянгол дүүргийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын бодлого-шинэчлэл” анхдугаар чуулганд 800 хүн оролцож үндэсний чуулганд оролцох 10 төлөөлөгчөө сонголоо.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын бодлого-шинэчлэл” үндэсний чуулганыг угтсан Баянгол дүүргийн “Оролцоог бодит болгоё” сарын аяны хүрээнд 23 хороо, ЕБС, СӨБайгууллагууд, Эрүүл мэндийн нэгдэл, Татварын хэлтэс, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Улаан загалмайн хороо, Замын цагдаагийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Спорт хороо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүл зэрэг нийт 26000 гаруй иргэд идэвхи санаачлагатай оролцлоо.

Дөрөв. Тохижилт, нийтийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр

Баянгол дүүрэг нь **294.903 га** газар нутагтай, засаг захиргааны **23** нэгж, статистик дүн мэдээгээр **11.318** байгууллага, аж ахуйн нэгжтэй, **49683** өрх, **192.614** хүн амтай.

2012 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар **1.087.094 м2** гэж тогтоосоноос уг нийтийн эзэмшлийн зам талбайд авто зам **167.080 м2**, явган хүний зам **247.956 м2**, ногоон байгууламж **620.667 м2**, бусад зам талбай **51.391 м2**.

4.1. Байгаль орчин, орчны бохирдол, хог хаягдлын чиглэлээр:

Тус дүүрэг нь Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээний хүрээнд түүхий нүүрсийг хязгаарлах хязгаарлалтын үндсэн бүсэд багтаж боловсруулсан түлш түгээх ажлыг 2011 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг ажлын хүрээнд боловсруулсан түлш хямдралтай үнээр борлуулахаас гадна иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийн дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг даргын “Агаарын чанарыг сайжруулах бүс шинэчлэн тогтоох тухай” 2013 оны А-13/А-30 дугаар хамтарсан тушаал, захирамж батлагдан гарч Баянгол дүүргийн гэр хорооллын 7, 9, 10, 11, 16, 20, 21, 22, 23-р хороодын айл өрхүүдийг боловсруулсан түлш болон бүрэн шаталттай ердийн зуух нэвтрүүлэх хосолмол бүсэд хамруулсан.

1. Дүүргийн Засаг даргын 2013 оны 07 дугаар захирамжаар “**Агаарын бохирдлыг бууруулах салбар хороо**”-г шинэчлэн байгуулж, салбар хорооны 2013 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан ажиллаж байна.

2. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд дүүргийн гэр хорооллын хороодод эрчим хүчний хэмнэлттэй, бүрэн шаталттай зуух нэвтрүүлэх болсонтой холбогдуулан айл өрхүүдэд сайжруулсан зуухыг сурталчилах, борлуулах ажлын нээлтийн өдөрлөгийг 2013 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан.

3. Хязгаарлалтын үндсэн бүсэд боловсруулсан түлшний 15 цэг ажиллаж байгаагаас гадна “Роял Өүшн” ХХК-ийн гэрийн болон ханан пийшингийн “Дөл” зуух, “Хүрд” ХК-ийн нам даралтын усан халаалтын зуухнууд нийлүүлэгдэж байна.

4. Энэ бүсэд Роял Өүшин ХХК-ний Дөл зуух, Хүрд ХК-ний Усан халаалтын нам даралтын зуух нийлүүлэгдэж байгаа бөгөөд одоогийн байдлаар **1397** өрх зуух авах захиалга өгч, **2225** өрхөд зуух нийлүүлэгдсэн байна.

5. Салбар хороо нь 7 хоног бүр борлуулалтын цэгт ажиллаж боловсруулсан түлшний захиалга, мэдээ тайлан, тооцоог нийлж нэгтгэн, иргэдэд хүртээмжтэй хүрч байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж, борлуулагчидтай хийсэн гэрээний дагуу борлуулсан түлшний орлогыг дансанд төвлөрүүлж одоогоор **349,668,000** /гурван зуун дөчин есөн сая зургаан зуун жаран найман мянган/ төгрөгийг Цэвэр агаарын санд тушаасан.

6. Баянгол дүүргийн гэр хорооллын 9 хороонд нийт **12461** өрхөд боловсруулсан түлш түгээх цэгүүдээр дамжуулан 2013 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар үртсэн шахмал түлш **2677.825** тн, хагас кокосжуулсан түлш **3950.144** тн нийт **6627.969** тн түлш хүлээж авч борлуулсан.

Давхардаагүй тоогоор **7574** өрх буюу **61,0%**-д нь боловсруулсан түлш хүрсэн.

7. БОНХЯ-ны Засгийн газрын тусгай сан “Цэвэр агаарын сан”-аас санхүүжиж буй агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын үндсэн бүсэд хяналт тавьж ажиллах орон тооны бус байцаагч 68 хэсгийн ахлагчид 1-р сарын урамшуулал болох **3.200.000** /гурван сая хоёр зуун мянган/ төгрөгийг олгосон.

8. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 6.1-д заасан нөхцөл, шалгууруудыг хангасан айл өрхийн цахилгааны үнийн хөнгөлөлтийг олгох ажлын хүрээнд дүүргийн цахилгаан эрчим хүч хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хамтран 2011 онд 4327 өрх 2012 онд **173** өрх нийт **4500** өрх одоогийн байдлаар гэрээ байгуулан цахилгааны хөнгөлөлтөнд хамрагдсан.

9. Дүүргийн хог хаягдлын оновчтой менежментийг хамтран хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, шинэ мэдлэг, мэдээлэлтэй болох, багаар хамтран ажиллах зорилгоор хороодын засаг дарга нар, хэсгийн ахлагч, тээвэрлэгч байгууллагыг хамруулсан сургалтыг зохион байгууллаа.

10. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд эрчим хүчний хэмнэлтэй, бүрэн шаталттай сайжруулсан зуух борлуулах, түгээх ажлыг эрчимжүүлэх зорилгоор

хязгаарлалтын үндсэн бүсэд хамрагдсан хороодын хэсгийн ахлагч нарын дунд 2013.03.01-нээс 2013.04.01-ний өдөр хүртэлх хугацаанд болзолт уралдаан зарласан.

11. Хог тээвэрлэлтийн үнэ тарифыг шинэчлэн ДИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулж мөрдөн, нийтийн эзэмшил, орон сууц, гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлын төлбөр тооцоо болон хог тээвэрлэлтэд гарах аливаа харилцааг зохицуулахаар хог тээвэрлэлтийн шууд гэрээг аж ахуйн нэгж, байгууллагуудтай шинэчлэн хийж эхэлсэн.

12. Нийтийн эзэмшлийн зам талбай болон авто замын хальтиргаа гулгааг арилгах, цас мөс хайлуулах зориулалтын бодис, давс, элс нөөцлөх ажилд 35,0 сая төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулж, давс, бодисыг татан цас мөсийг тухай бүр арилгуулах ажилд хяналт тавьж ажилласан.

13. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, Дүүргийн хэмжээнд иргэдийг эрүүл, аюулгүй, цэвэр орчинд аж төрөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нийтийн эзэмшил, орон сууц, гэр хорооллын гудамж талбайд үүссэн хог хаягдал, цас мөс, хальтиргаа гулгаа, нийтийн өмчийн эд хөрөнгийг цэвэрлэх бүх нийтийн их цэвэрлэгээг долоо хоног бүр зохион байгуулж хэвших зорилгоор **“Баянголчуудын Бямба гариг”** их цэвэрлэгээний нээлтийг хийж иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хүргэх, сурталчилгааны самбаруудыг байршуулах, хэвлэл, радио телевизерээр сурталчлан Дүүргийн Засаг даргын 2013 оны 1/325 дугаар захирамжаар нийтийн их цэвэрлэгээг долоо хоног бүрийн Бямба гаригт 11.00-14.00 цагийн хооронд тогтмол зохион байгуулж байна.

14. Баянгол дүүргийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран **“Эзэнтэй Монгол”** хөтөлбөрийн хүрээнд хороо бүрт цэвэрлэгээ хариуцсан 2-5 хүнийг урамшуулалтай ажиллуулж, дүүргээс хороо бүрийг цэвэрлэгээнд шаардлагатай багаж хэрэгсэл, тэрэг, чанга яригч, сурталчилгааны плакат материалаар хангасан.

4.2. Гэрэлтүүлгийн чиглэлээр:

15. Нийтийн эзэмшлийн зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийн асалт, гэмтэл, засвар үйлчилгээнд засвар ашиглалтыг хариуцсан **“Цахилгаан тээвэр ХК”**-тай хамтран долоо хоног бүрийн **“Пүрэв”** гаригт тогтмол үзлэг хийж, засвар үйлчилгээг шуурхай хийлгэж байна.

3 сарын 18-ны байдлаар	НЭЗТ	Орон сууц	Гэр хороолол	Дундаж асалтын хувь
Асалтын хувь	86.5%	86%	73.3%	81.9%

4.3. Гадна зар сурталчилгааны байгууламжийн чиглэлээр:

16. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 3/32 тоот тогтоолоор **“Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгааны байгууламжийг байруулахад дагаж мөрдөх журам”**-ыг шинэчлэн баталж дээрхи байгууламжийг дүүрэг хариуцах үүрэг, хариуцлага шилжин ирсэн.

Үүний дагуу зар сурталчилгааны байгууламжинд тооллого хийж журамд заагдсан байршилд гадна зар сурталчилгаа байршуулахыг хориглосон 30 газрын судалгааг гаргаж мэдэгдэх хуудас хүргүүлж, эхний шатанд хашаа хайс, явган хүний зам дагуу байршуулсан зар сурталчилгааны самбарыг албадан буулгах ажлын хэсэг байгуулж, бэлтгэл ажлыг хангаж байна.

17. Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх, хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт тавигдсан камерийн системийг тоолох, ажиллагааны бүрэн бүтэн байдлыг шалгах, эзэнжүүлэх, шинээр камержуулалт хийх байршлыг тогтоох ажлын хэсэг дүүргийн Засаг даргын 2013 оны А/126 дугаар захирамжаар байгуулагдан ажиллаж эхэлсэн.

4.4. Дэд бүтэц, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын чиглэлээр:

18. “Орон сууц, Сууц өмчлөгчдийн холбоо, Барилгын өнөөгийн байдал, цаашдын зорилт” сэдэвт анхдугаар зөвлөгөөнийг Орон сууц, Нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтнуудын дунд зохион байгуулсан.

19. Иргэдийн өргөдөл гомдлын дагуу ШӨХТГ-тай хамтран 1 дүгээр сард зарим СӨХ-доор шалгалт хийж 12 холбоонд албан шаардлага хүргүүлж, 29 иргэний гомдлыг барагдуулж биелэлтийг хангуулан ажиллаж байна.

20. Шинээр ашиглалтад орсон болон харьяалалгүй орон сууцны сууц өмчлөгчдийн хурлын шийдвэр, холбогдох баримт бичгийг үндэслэн шинээр байгуулагдсан 5 СӨХ-г бүртгэн авч гэрчилгээ олгосон.

21. Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа инженерийн шугам сүлжээний /дулаан, бохир, үерийн шугам, холбоо, цэвэр усны худаг/ тооллогыг 23 хороонд хийж эзэн холбогдогчдыг тогтоож засвар үйлчилгээ, тагжуулах ажлыг хийлгэж эхэлсэн.

4.5. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:

Хуулийн хэрэгжилтийн талаар зохион байгуулсан ажил: “Тамхины хяналтын хууль” шинээр батлагдан 2013 оны 03 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан хууль сурталчилах сургалтыг 2013 оны 02 сарын 19-нд дүүргийн бүх хороодын болон сургуулийн нийгмийн ажилтан нар, Цагдаагийн 1, 2-р хэлтсийн хэв журмын ажилтан нарт сургалт зохион байгуулав. Газрын албатай хамтран дүүргийн хэмжээнд ажиллаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн бүх сургуулиудын 500м бүхий зураглалыг гаргаж, тамхи худалдаалахыг хориглосон байрлалыг тэмдэглэж 23 хороонд тараасан.

Хяналт шалгалтын талаар: 2013 оны 03 сарын 29-31-ний өдрүүдэд Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтарч Засаг даргын захирамжийн дагуу удирдамж боловсруулан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй саунуудад шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар 15 зөрчил илрүүлэн Мэргэжлийн хяналтын улсын байцаагч 13-г нь газар дээр нь арилгуулж, 2 байгууллагын үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар түр зогсоож 12 заалттай 3 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч 2 иргэнд холбогдох хуулийн заалтын дагуу 45,0 мян төгрөгийн шийтгэврээр захиргааны арга хэмжээ ногдуулсан.

Тайлангийн хугацаанд цаг хэтрүүлэн ажилласан, Худалдааны газрын стандартын шаардлага хангахгүй 6 баар, 8 дэлгүүрийн Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг Захирагчийн ажлын албанд хүргүүлэн хүчингүй болгон хяналт тавин ажиллаж байна.

Зохион байгуулж хийсэн ажил: Тамхи худалдах тусгай зөвшөөрөл, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх гэрчилгээг Засаг даргын захирамж гарган шинэчилсэн лого бүхий гэрээ, гэрчилгээг шинээр хэвлүүлэх ажлыг зохион байгуулсан.

Тайлангийн хугацаанд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх 120 гэрчилгээ олгосон. Мөн тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл 23 олгож, төсөвт 5,350,000 төгрөг, дүүрэг хөгжүүлэх санд 1,200,000 төгрөг оруулаад байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан дүүргийн алдарт эхчүүд, эмэгтэйчүүдэд хүндэтгэл үзүүлэх 3000 ээжийн “БАЯНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮД” хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээг Засаг даргын захирамжаар Засаг даргын орлогч Г.Энхболд даргаар ахлуулан ажлын хэсэг байгуулан зохион байгуулж ажиллаа.

Тав. Захиргааны үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулах

5.1. Захиргааны үйлчилгээний хүртээмжийн талаар:

Нийслэл, дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, 2012 оны эдийн засаг, нийгмийн зорилтын биелэлтийг харъяа хэлтэс албад, хороодоос нэгтгэн авч, үр дүнг тооцож, удирдах дээд шатны удирдлагад танилцуулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Дүүргийн Захиргаа, хуулийн хэлтсийн хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн 23-н хороогоор явж цаг үеийн ажил байдалтай танилцаж, иргэдэд төрийн үйлчилгээ хүргэх, дээд газрын бодлого шийдвэрийг иргэдэд сурталчилж ажиллах талаар зөвөлгөө өгч, хороодын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Дүүргийн 22 дугаар хороонд хэрэгжих “1 цонхны үйлчилгээний төв” төслийн ажиллагаа хэрэгжих шатандаа явж байна.

5.2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, архив албан хэрэг хөтлөлт хариутай бичгийн шийдвэрлэлт:

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирж байгаа өргөдөл гомдлыг албан хаагчдын болон иргэдийн гэсэн 2 төрлөөр ангилан бүртгэл хөтлөн ажиллаж байна.

A/ Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал:

Улаанбаатар сонсож байна “Цахим өргөдөл, гомдлын нэгдсэн систем”-ийг ашиглан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шилжүүлэх, шийдвэрлүүлэх, эргэн мэдээллэх үйл ажиллагааг удирдлагын заалтын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2013 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 313 өргөдөл, гомдол ирсэн байна.

“Цахим өргөдөл, гомдлын нэгдсэн систем”-ээр ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:

№	Ангилал	Нийт		Шийдвэрлэх шатандаа байгаа		Шийдвэрлэж хариу өгсөн	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Call center	86	27,48%	17	36,17%	69	25,94%
2	Ub.1200.mn	8	2,56%	0	0%	8	3,01%

3	11 – 11 төв	55	17,57%	10	21,28%	45	16,92%
4	Иргэдийг хүлээн авах төв	7	2,24%	0	0%	7	2,63%
5	Байгууллага	157	50,16%	20	42,55%	137	51,50%
6	Нийт	313	100%	47	15%	266	85%

Б/ Албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:

№	Нийт	Шийдвэрлэх шатандаа		Шийдвэрлэж хариу өгсөн	
		Тоо	Хувь	Нийт	Хувь
1	33	6	18%	27	82%


В/ “Цахим өргөдөл, гомдлын нэгдсэн систем”-д бүртгэгдээгүй буюу программд ороогүй Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, харъяа газруудын 2013 оны 1-р улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ:

№	Байгууллага	Нийт	Шийдвэрлэх шатандаа		Шийдвэрлэж хариу өгсөн	
			Тоо	Хувь	Нийт	Хувь
1	ХГХА	8650	731	8%	7919	92%
2	Хороод	5258	0	0%	5258	100%
3	НИЙТ	13908	731	5%	13177	95%

Баянгол дүүргийн хэмжээнд нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал:

№	Байгууллага	Нийт	Шийдвэрлэх шатандаа		Шийдвэрлэж хариу өгсөн	
			Тоо	Хувь	Нийт	Хувь
1	Smartcity.mn	313	47	15%	266	85%
2	ЗДТГ	33	6	18%	27	82%
3	ХГХА	8650	731	8%	7919	92%
4	Хороод	5258	0	0%	5258	100%
5	НИЙТ	14254	784	6%	13470	94%

Графикаар харуулбал:



2. Долоо хоног бүрийн 3 дахь өдөр Засаг даргын иргэд хүлээн авах уулзалтаар гарч буй иргэдийн гомдол, санал, хүсэлтийг тэмдэглэл хөтлөн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна. 2013 оны 1 дүгээр улирлын байдлаар Засаг дарга нийт 138 иргэнийг хүлээн авч уулзаж, тэдний өргөдөл хүсэлтийг хүлээн авч шууд шийдвэрлэх боломжтой өргөдөл, гомдол, санал хүсэлтийг холбогдох мэргэжилтнүүдийг нь байлцуулан асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан.

“Алдарт эх” нэгдүгээр зэргийн одонгоор шагнагдах – 62, хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах – 286, нийт 348 эхийн материалыг Засаг даргын шийдвэрийн хамт дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчидэд уламжилсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийн дагуу “Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах тухай журам”-ыг үндэслэн дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн болон хороо дүүргийн ахмад настан, ажил үйлсээрээ тэргүүний 110 иргэний материалыг холбогдох заалтын дагуу бүрдүүлж, тусгай программд шивсэний дагуу НЗДТГазарт хүргэсэн.

5.3 Хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр:

Үдб̄ ççé, ñóðãàèò, òàðèòõñàì ÿðäÿæèèòÿí ïü иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө, туслалцааг үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд 1 дүгээр улиралд 20 иргэнд иргэн, захиргааны чиглэлээр зөвлөгөө өгч үйлчилсэн байна.

5.4. Хүний нөөцийн удирдлага, сургалт хөгжлийн төлөвлөлт:

17 хорооны Засаг дарга нарыг ажлаас чөлөөлж, үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон дарга нарын ажил хүлээлцүүлсэн.

Бүтцийн өөрчлөлтөөр томилогдсон 28, чөлөөлөгдөж, тэтгэмж хүссэн 11, шинэ хүүхэд төрүүлэн тэтгэмж хүссэн 2 албан хаагчийн асуудлыг шийдвэрлэсэн.

Архив албан хэрэг хөтлөлтийн талаар ажлын байран дахь сургалтыг 1 удаа зохион байгуулж 176 албан хаагч хамрагдсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн

хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байгаа, энэ чиглэлээр нийт 23 хорооны Засаг нар болон Засаг даргын Тамгын газрын ажилтнуудад “Ёс зүй”-н чиглэлээр ШУТИС-н ахлах багш, магистр Д.Төрмөнхөөр лекц уншуулж, сургалт орсон.

5.5. Мэдээллийн технологи, сүлжээний ашиглалт:

1. ЗДТГ-ын хэмжээнд албаны и-мэйл хаяг, outlook программыг нэвтрүүлж, түүнийг хэрэглэх сургалт зохион байгуулсан.
2. Хороодын ажилтан, албан хаагчдын компьютерт лицензтэй вирусын программ суулгасан.
3. ЗДТГ болоод хороодын ажилтан албан хаагчдын компьютер, техник хэрэгсэлд тооллого хийж, шаардлагатай компьютер, техник хэрэгслийг засварласан.

5.6. Мэдээллийн сан бүрдүүлэлт, мэдээллийн үйлчилгээ:

1. Хэвлэл мэдээллийн алба нь 2013 оны турш ETV, МҮОНР, Өдрийн сонин, Зууны мэдээ, Улаанбаатар таймс, Ардчилал, www.news.mn, www.times.mn сайтуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, одоогийн байдлаар цахим хуудсуудын гэрээний төлбөрийг барагдуулаад байна. Мөн хэвлэл мэдээллийн албанд шаардлагатай өнгөт принтер, зургийн аппарат, дуу хураагуур зэргийн судалгааг гаргаж, холбогдох хүмүүст хүргүүлсэн болно.
2. ETV, ZATV, МҮОНР-гоор Баянголчуудын бямба, шинэчлэлийг хамтдаа цуврал нэвтрүүлэг бэлтгэн цацсан бөгөөд одоогийн байдлаар 10 дахь удаагийн нэвтрүүлэг хийгдэж байна. Мөн Баянголчуудын бямба кампанит ажлыг дээрх телевизүүдтэй хамтран өрнүүлээд одоо 10 дахь долоо хоногийнхоо тоймыг бэлтгэж байна.
3. Мөн Баянгол дүүргийн цахим хуудсыг шинэчлэн нээсэн бөгөөд Баянгол дүүргийн Засаг даргын фэйсбүүк, твиттер хуудсыг тогтмолжуулаад байна. Засаг даргын фэйсбүүкт өнөөдрийн байдлаар долоо хоногийн дундаж үзүүлэлт нь 1600 гаруй хүн ханддаг гэсэн судалгаа гарчээ. Вэб баяжуулалт эхний байдлаар хийгдсэн бөгөөд харъяа хэлтсүүдийн мэдээлэл ороогүй үлджээ.
4. Баянгол дүүргийн брэндбүүкийг захиалан хийлгэсэн бөгөөд энэ ажлын явц 90 хувьтай байгаа ба тавдугаар сарын эхний долоо хоногт багтаан дуусгана. Үүнээс гадна хоёрдугаар сард Баянгол дүүргийн Шинэчлэлийн багийг танилцуулах зорилгоор сонины тусгай дугаарыг “Өнөөдрийн тойм” сонины редакцынхантай хамтран хэвлэж, өрх бүрт түгээсэн болно.
5. Үүнээс гадна Баянгол дүүрэг утаагүй түлшний хосолмол бүс болсон, Засаг даргын 2012-2016 оны мөрийн хөтөлбөр, 2013 оны нийгэм, эдийн засгийн зорилт батлагдсан, Төсөвт иргэдийн оролцоог эрхэмлэх болсон, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний чуулганыг угтсан “Оролцоог бодит болгоё” сарын аян зэрэг арга хэмжээнд төлөвлөгөө гарган ажиллажээ. Ингэхдээ Баянголчуудын бямба аяны нээлтийг үйл ажиллагааг эс тооцвол аль ч үйл явдалд хэвлэл мэдээллийн, сурталчилгааны төсөв гаргаж аваагүй болно.

5.7. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг, хөтөлбөр төслийн хяналт шинжилгээ, үнэлгээ:

Дүүргийн Засаг даргын захирамж, Тамгын газрын тушаалын төсөл, хамтран ажиллагч байгууллагуудын гэрээ зэрэг 30 гаруй бичиг баримтанд албан хэрэг хөтлөлтийн болон хууль зүйн горим, журмаар хянан засварласан.

Зургаа. Цэргийн тоо бүртгэл, цэрэг татлагын ажлын талаар

6.1.2013 оны цэргийн тоо бүртгэлийн үед хийгдсэн ажил: Нийслэлийн Засаг даргын 2012 оны А/714, дүүргийн Засаг даргын 2012 оны А/503 дугаар захирамжуудыг үндэслэн, цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын 2013 оны тоо бүртгэлийг зохион байгуулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас тус дүүргийн хэмжээнд явагдаж байгаа цэргийн тоо бүртгэлийн ажилтай танилцаж, цэргийн тоо бүртгэлийн мэдээллийн сан, тоо бүртгэлийн явцын талаар мэдээлэл сонссон.

Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын 2013 оны тоо бүртгэлийг тогтоосон хугацаанд 93,9 хувьтай зохион байгуулж дууссан.

Зэвсэгт хүчний 92 жилийн ойг угтан дүүргийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулагдах “Дөл” тоглолтын заавар, “Монгол цэргийн жавхаа” сэдэвт зохион бичлэгийн уралдааны болзлыг ерөнхий боловсролын 18 сургуульд тараасан.

6.2. “Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 92 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан ажил:

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 92 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/120, дүүргийн Засаг даргын А/96 дугаар захирамжууд гарсан.

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас 2013 оныг “Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх жил” болгон дэвшүүлсэн зорилтын хүрээнд дүүргийн Засаг даргаар батлагдсан “Монгол цэрэг”-ийн өдөр, Зэвсэгт хүчний 92 жилийн ойн ажлын төлөвлөгөөний дагуу 2013 оны 02 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд хороодод ажиллаж, хаалтын ажиллагааг 02 дугаар сарын 28-ны өдөр дүүргийн “Оюуны ундраа” цогцолбор сургуулийн урлаг зааланд “Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх нь бидний ажил” сэдэвт ажлаа сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулан хүргэх арга хэмжээ болсон.

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 92 жилийн ойн нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын төлөвлөгөөний дагуу 03 дугаар сарын 14-нд Соёлын төв өргөөнд нийслэлийн 3 үеийн уулзалт цэнгүүнд тус дүүргийн ЕБС-ийн 100 сурагч, хороодоос 150 иргэнийг оролцуулж, Цэргийн штаб иргэдэд ажлаа сурталчлан 25 иргэний асуудлыг,

03 дугаар сарын 17-ны өдөр UB palace-д дүүрэгт амьдардаг генерал цолтнууд болон 23 хорооны иргэдийн төлөөллийг хүлээн авч, тэмцээн, уралдаанд түрүүлсэн сургууль, сурагч, 2013 оны цэргийн тоо бүртгэлийг амжилттай зохион байгуулсан хороо, зохион байгуулагч нарт шагнал гардуулж, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан.

Уг арга хэмжээний үед Батлан хамгаалахын төв архив, Монгол цэргийн музейтэй хамтран ажиллаж, Цэргийн штаб ажлаа иргэдэд ажлаа танилцуулж 5 иргэн архивын лавлагаа авч, 28 иргэний асуудлыг шийдвэрлэж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2013 оны А/12 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2013 оны А/127 дугаар захирамжаар хорооны Засаг дарга нарын 2013 оны цэргийн бэлтгэл сургалтыг 2013 оны 03 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Тус Цэргийн штабын төлөвлөгөөгөөр 2013 оны 03 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн байрлалд сургалтыг зохион байгуулсан.

6.3.2013 оны 1 дүгээр ээлжийн цэрэг халалт, татлагын бэлтгэл ажлын талаар:

2013 оны 1 дүгээр ээлжийн цэрэг халалт, татлагын ажлыг зохион байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/347 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын А/168 дугаар захирамж гарч, цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь, зарцуулагдах хөрөнгө, цэргийн жинхэнэ албанд татагдагчдын нэрсийн жагсаалтыг тус тус баталсан.

Дүүргийн хэмжээнд зарлан дуудах хуудас 3500 иргэнд бичигдэж, тараалт 95,7 хувьтай байна.

Цэрэг халалт, татлагын бэлтгэл ажлыг 28 асуудлаар төлөвлөснөөс 21 ажил биелж, 7 ажил цэрэг татлагын үеэр болон дууссаны дараа биелэлт нь гарна. Төлөвлөгөөний биелэлт 75 %-тай байна.

Дүүргийн 23 хороонд цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангах тухай удирдамжийг хүргүүлэн мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгах ажил 2013 оны 04-р сарын 25-ны байдлаар 52 иргэнээр төлбөр төлүүлж, Нийслэлийн төрийн санд төвлөрүүлээд байна.

ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Т.НЯМЦЭЦЭГ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ЗХХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Т.ЭРДЭНЭГАВАА